



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 39/39

Улаанбаатар хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.а заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01/6487 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нийслэл дэх төр, хувийн хэвшлийн түншлэл” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэл дэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг зохицуулах журмыг батлахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

3.Дэд хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.


ДАРГА



Р.ДАГВА

1110100151

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2019 оны 12 дугаар сарын 26-ны
өдрийн 30/39 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Үндсэн асуудал

1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр зүйлийн зорилго хэсэгт “Хотын засаглалын хүрээнд бизнес эрхлэхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, санхүүжилтийн шинэлэг тогтолцоог нэвтрүүлж, эдийн засгийн өсөлтийг хангана” гэж заасан.

1.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5 дахь хэсэгт “Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” гэж, 1.5.5 дахь заалтад “Нийслэлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэрийг ашиглан зохион байгуулж, харилцан ашигтай хамтын ажиллагааны механизм бүрдүүлнэ” гэж заасан.

1.3.Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн “Иргэд, олон нийт болон хувийн хэвшлийг төрийн үйлчилгээнд татан оролцуулдаг Сайн засаглалтай, дэвшилтэт хууль эрх зүйн орчин бүхий хот байна” гэсэн 3 дугаар тэргүүлэх чиглэлийн 3.2 дахь зорилтод “Олон нийтийн үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, хувийн хэвшлийн оролцоог дэмжих” гэж заасан.

1.4.Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн 3 дугаар ботийн Замын байгууламж хэсэгт “... Улаанбаатар хотод төлбөртэй зогсоолын үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.” гэж заасан.

1.5.Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичиг болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд төр ба хувийн хэвшлийн түншлэлийг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймд Нийслэл хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх механизмын сайжруулах зорилгод үндэслэн “Нийслэл дэх төр, хувийн хэвшлийн түншлэл” дэд хөтөлбөрийг боловсруулсан болно.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, Концессын тухай хууль батлагдсанаас хойш Нийслэлээс төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийтдээ 21 төсөл, хөтөлбөр, барилга, байгууламжийг концессын болон Хамтарсан компани байгуулах хэлбэрээр хэрэгжүүлсэн байна. Үүнээс 19 барилга, байгууламж нь концессын гэрээний үндсэн дээр хэрэгжүүлсэн бол Улаанбаатар хотын нийтийн тээврийн цахим тасалбарын төсөл болон Улаанбаатар хотыг байгалийн хийгээр хангах гэсэн 2 төсөл хамтарсан компани байгуулах хэлбэрээр хэрэгжиж байгаа болно. Өнөөдрийн байдлаар Нийслэлээс төр, хувийн хэвшлийн түншлэлийн бусад хэлбэрээр өөр төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

1.6.Энэхүү дэд хөтөлбөрт заасан “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж “Нийслэлээс иргэдэд үзүүлэх дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хамтарсан компани байгуулах хэлбэрээр хэрэгжүүлэн ажиллах харилцаа”-г ойлгоно.

1.7.Нийслэлд хэрэгжүүлэх Төр, хувийн хэвшлийн түншлэл (цаашид “ТХХТ” гэх)-ийн төсөл, хөтөлбөр нь дараах шинжийг агуулсан байна.

1.7.1.Тухайн төсөл, хөтөлбөрийг Нийслэл өөрийн хөрөнгөөр эсхүл дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх нь судалгаагаар нотлогдсон байх;


1.7.2.Нийслэлд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхээр хувийн хэвшил санаачилга гарган, төсөл, хөтөлбөр боловсруулан ирүүлсэн ба түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх нь судалгаагаар нотлогдсон байх;

1.7.3.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа орон сууцжуулалт, хөрөнгийн менежмент, агаар, хөрсний бохирдол, замын түгжрэл, хот төлөвлөлт, дэд бүтэц, хог хаягдал, нийтийн тээвэр зэрэг үйлчилгээний үр ашиг, нийгэм, эдийн засгийн өгөөжийг сайжруулах зорилгоор дахин загварчлах төсөл, хөтөлбөрүүдийг хувийн хэвшил, иргэдээс санал болгосон байх;

Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1.Дэд хөтөлбөрийн зорилго: Нийслэлийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төсвийн ачааллыг бууруулах, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж хамтран ажиллахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Дэд хөтөлбөрийн зорилт:



2.2.1.Хөрөнгө, санхүүгийн хомсдлоос шалтгаалан хэрэгжээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа төслүүд болон шинээр хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг эрэмбэлж, түншлэлээр хэрэгжүүлэх судалгаа хийх;

2.2.2.Нийслэлийн хөгжлийн төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хөрөнгө оруулагч нартай уулзах, сурталчлан таниулах, гэрээ, хэлэлцээр байгуулах;

2.2.3.Нийслэлийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаарх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих;

2.2.4.Нийслэлийн хөгжлийн төслүүдийн төсөвт учруулах ачааллыг нарийвчлан судлах;

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

3.1.Энэхүү хөтөлбөрийг 2020-2025 оны хооронд 5 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

3.2. Нэгдүгээр зорилтын хүрээнд

3.2.1.Нийслэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжиж эхлээгүй эсхүл хэрэгжиж эхэлсэн боловч зогсонги байдалтай байгаа төслүүдийн жагсаалтыг гаргаж, эдийн засгийн тооцооллыг хийнэ.

3.2.2.Холбогдох хөгжлийн баримт бичгүүдийг судалж хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг гаргаж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

3.3.Хоёрдугаар зорилтын хүрээнд

3.3.1.Нийслэлээс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрийг судалгааны үндсэн дээр олон нийтэд сурталчлан танилцуулах, хөрөнгө оруулагч нарт үр өгөөжийн талаар сурталчлан таниулна.

3.3.2.Төлөвлөгдсөн төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх боломжтой хөрөнгө оруулагч нартай хэлцэл хийх, төслийн хөрөнгө оруулалтыг нарийвчилна.

3.4.Гуравдугаар зорилтын хүрээнд

3.4.1.Нийслэлийн иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг сайжруулах талаар хувийн хэвшил санал, санаачилга гаргаж төсөл, хөтөлбөр боловсруулсан тохиолдолд түүний үр өгөөж, нөхцөл байдлыг судлан үзэж сонгон шалгаруулалт зарлахгүйгаар хэрэгжүүлэх боломжтой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

3.4.2.Нийслэлийн иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхүйц дэвшилтэт техник, технологийн санал, санаачилгыг дэмжинэ.



3.4.3.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхүйц менежментийн сайн арга барил, олон улсын туршлагын талаарх санал, санаачилгыг дэмжинэ.

3.5.Дөрөвдүгээр зорилтын хүрээнд

3.5.1.Нийслэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн төсөвт үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судална.

3.5.2.Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн төсөвт үзүүлэх нөлөөллөөс шалтгаалж бусад санхүүжилтийн боломжит хувилбаруудын талаарх судалгааг хийх.

Дөрөв. Дэд хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

Үр нөлөө: Нийслэл хотод хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг зөвхөн концессын гэрээнээс бусад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хурдан, шуурхай хэрэгжүүлэх боломж бүрдэж, хувийн хэвшлийн санаачилгыг бодитоор дэмжинэ.

Бүтээгдэхүүн: Нийслэлд шаардлагатай байгаа хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хувийн хэвшлийн санаачилга, хөрөнгө оруулалтаар бодит ажил болгоно.

Шалгуур үзүүлэлт: Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх өртөг зардлын шинжилгээг хийж бусад хувилбартай жишиж, үр ашгийн тооцоог хийсэн байх;

Нийслэлд түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр нь байгаль орчинд ээлтэй, шинэ технологи нэвтрүүлсэн байх;

Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч хувийн хэвшил хөрөнгө оруулалтын үр өгөөжөө урт хугацаанд хүртэх боломжтой байх;

Төрийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог хангаж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлсэн олон улсын туршлагыг судалсан байх.

Тав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр


5.1.ТХХТ-ээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санхүүжилтийн дараах хэлбэрүүдийг ашиглана.

5.1.1.Урт хугацааны гэрээг үндэслэн хувийн хэвшлээс хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэр;

5.1.2.Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй орон нутгийн төсвийн санхүүжилт;

5.1.3.ТХХТ-ээр хэрэгжих төслийн үйл ажиллагааны орлого, төлбөрт үйлчилгээний орлого;

5.1.4.Түншлэгч талууд хөрөнгийн зах зээлд хувьцаа, үнэт цаас гаргах замаар бүрдүүлсэн санхүүжилтийн эх үүсвэр;



5.1.5.Олон улсын байгууллага, төр, хувийн хэвшил, иргэдийн зүгээс төслийг дэмжиж өгсөн хандив, тусламж;

5.1.6.Хөрөнгө оруулагч талуудад ногдох хувьцааны ногдол ашиг, ногдол ашгийн хуваарилалтаас орох санхүүжилт;

5.1.7.ТХХТ-ийн эрх зүйн орчинд зөвшөөрөгдсөн бусад санхүүжилтийн эх үүсвэр.

5.2.Түншлэлийн үйл ажиллагаанд тохиромжтой санхүүжилтийн оновчтой хувилбарыг сонгож хэрэгжүүлэх үүргийг түншлэлд оролцогч талууд хүлээж түншлэлийн гэрээнд тодорхой тусгана.

Зургаа. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

6.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжоор хангаж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулан, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.


6.2.Төсөл тус бүрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг түншлэлийн гэрээнд тусгаж талууд шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг үнэлэх үүргийг түншлэлийн талууд хүлээнэ.

6.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүхэлд нь хянаж, хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 2 жил тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

6.5.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна.

6.6.Нийслэлд ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг сонгох, хэрэгжүүлэх журмыг энэхүү хөтөлбөрт нийцүүлэн боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар баталж, мөрдүүлнэ.

--00--



“НИЙСЛЭЛ ДЭХ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА

№	“Нийслэл дэх төр, хувийн хэвшлийн хөтөлбөрийн хөтөлбөрийн зорилго	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	Бусад бодлогын баримт бичиг
		<p>Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030</p>	<p>Нийцэж байгаа зорилго, зорилт</p>
1	<p>Нийслэлийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төсвийн ачааллыг бууруулах, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030</p> <p>2.1.Эдийн засгийн тогтвортой хөгжил зорилтын Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим: Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн санхүү, эдийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах</p> <p>2.4.Тогтвортой хөгжлийн засаглал зорилтын Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим: Зорилт 2. Төрийн бүх шатны байгууллагын улирллагын манлайппыг</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төвлөлгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага</p> <p>3.2. Олон нийтийн үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, хувийн хэвшлийн оролцоог дэмжих</p> <p>2.4.1.4Улаанбаатар хотод төлбөртэй зогсоолын үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.</p>
		<p>Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>5.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашиг ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>1 дүгээр зүйлийн зорилго хэсэгт “Хотын засаглалын хүрээнд бизнес эрхлэхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, санхүүжилтийн шинэлэг тогтолцоог нэвтрүүлж, эдийн засгийн өсөлтийг хангана.</p> <p>1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</p>

УХА0.283

	<p>Дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.</p>			<p>1.5.5. Нийслэлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэрийг ашиглан зохион байгуулж, харилцан ашигтай хамтын ажиллагааны механизм бүрдүүлнэ.</p>
--	--	--	--	---

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" баримт бичгээр Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах, Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлэх асуудлыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" баримт бичигт "Иргэд, олон нийт болон хувийн хэвшлийг төрийн үйлчилгээнд татан оролцуулдаг Сайн засаглалтай, дэвшилтэт хууль эрх зүйн орчин бүхий хот байна" гэсэн тэргүүлэх чиглэлд заасан Олон нийтийн үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, Улаанбаатар хотод төлбөртэй зогсоолын үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг Нийслэлд хэрэгжүүлэхийн тулд уг дэд хөтөлбөрийг уялдуулан боловсруулав.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөр батлагдсан Хотын засаглалын хүрээнд бизнес эрхлэхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, санхүүжилтийн шинэлэг тогтолцоог нэвтрүүлж, эдийн засгийн өсөлтийг хангана. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ, Нийслэлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэрийг ашиглан зохион байгуулж, харилцан ашигтай хамтын ажиллагааны механизм бүрдүүлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

УХА0203

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨР, ХУВИЙН ХЭВШИЛ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ**

Гуравдугаар хавсралт

№	Бодлогын баримт бичгийн холбогдох заалт	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх Байгууллаг-ууд	
					Он	Үзүүлэлт			
Бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд									
1	Нийслэлийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төсвийн ачааллыг бууруулах, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжихэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.	Хөрөнгө, хомстлоос хэрэгжээгүй, удаашралтай төслүүд болон шинээр хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг эрэмбэлж, түншлэлээр хэрэгжүүлэх судалгаа хийх	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж байгаа төслүүд болон хэрэгжүүлэх төслүүдийн судалгаа хийсэн байдал	Тоо	2019	21	2025	45	Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд
2	оргуулалтыг татах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төсвийн ачааллыг бууруулах, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжихэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.	Нийслэлийн хөгжлийн төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хөрөнгө оруулагч нартай уулзах, сурталчилна таниулах, гэрээ, хэлэлцээр байгуулах	Шинээр эхлүүлсэн түншлэлийн төсөл	Тоо	2019	21	2025	45	Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд
3	Нийслэлийн үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг талаарх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	иргэдэд төрийн чанар, дээшлүүлэх талаарх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	Хувийн хэвшлээс боловсруулж ирсэн төсөл, судалгаа	Тоо	2019	-	2025	24	Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд
4	Нийслэлийн төсөвт ачааллыг судлах	Нийслэлийн хөгжлийн төсөвт ачааллыг судлах		100	2019		2025		Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд

“НИЙСЛЭЛ ДЭХ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТЛАХ БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Нийслэлийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төсвийн ачааллыг бууруулах, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжихэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Нийслэл хотод хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг зөвхөн концессын гэрээнээс бусад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хурдан, шуурхай хэрэгжүүлэх боломж бүрдэж, хувийн хэвшлийн санаачилгыг бодитоор дэмжинэ.				
1. Үйл ажиллагааны чиглэл						
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1 дүгээр зорилтын хүрээнд						
1	Хөрөнгө, санхүүгийн хомсдолоос шалтгаалан хэрэгжээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа төслүүд болон шинээр хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг эрэмбэлж, түншлэлээр хэрэгжүүлэх судалгаа хийх	Нийслэл дээр төлөвлөсөн боловч эсхүл хэрэгжиж зогсонги байдалтай жагсаалтыг засгийн тооцооллыг хийнэ.	Төсөл тус бүрээр гаргасан тооцоо, судалгаа хийсэн байдал	Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2020 оны II улирал
2	Холбогдох бичгүүдийг шаардлагатай эрэмбэлж, түншлэлээр хэрэгжүүлэх судалгаа хийх	Холбогдох бичгүүдийг шаардлагатай жагсаалтыг батлуулна.	НИТХ-аас батлагдсан шийдвэр	Тамгын газрын төсөл, хөтөлбөр хариуцсан нэгж	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2020-2025 он
2 дугаар зорилтын хүрээнд						
1	Нийслэлийн хөгжлийн төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах	Нийслэлээс төлөвлөсөн судалгааны сурталчилна оруулагч нарт үр сурталчилна таниулна.	Хөрөнгө оруулагч нараас ирүүлсэн санал	Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2020 - 2025 он

2	<p>чиглэлээр хөрөнгө оруулагч нартай уулзах, сурталчилан таниулах, гэрээ, хэлэлцээр байгуулах</p>	<p>Төлөвлөгдсөн төсөл, хамтран хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч нартай хэлцэл хийх, төслийн хөрөнгө оруулалтыг нарийвчилна.</p>	<p>Хөрөнгө оруулагч нараас ирүүлсэн санал</p>	<p>Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>2020-2025 он</p>
3 дугаар зорилтын хүрээнд						
1	<p>Нийслэлийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаарх хувийн санаачилгыг дэмжих</p>	<p>Нийслэлийн иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг сайжруулах талаар хувийн хэвшил санал, санаачилга гаргаж төсөл, хөтөлбөр боловсруулан ирсэн тохиолдолд үр өгөөж, нөхцөл байдлыг судлан үзэж сонгон шалгаруулалт зарлахгүй байдлаар хэрэгжүүлэх боломжтой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.</p>	<p>Холбогдох дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал</p>	<p>Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>2020-2025 он</p>
2	<p>Нийслэлийн иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаарх хувийн санаачилгыг дэмжих</p>	<p>Нийслэлийн иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхүйц дэвшилтэт техник, технологийн санал, санаачилгыг дэмжинэ.</p>	<p>Дэвшилтэт технологийн нэвтэрсэн байдал</p>	<p>Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>2020-2025 он</p>
3	<p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхүйц менежментийн сайн арга барил, олон улсын туршлагын талаархи санал, санаачилгыг дэмжинэ.</p>	<p>Гадаад орны туршлагын нэвтэрсэн байдал</p>	<p>Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>2020-2025 он</p>
4 дүгээр зорилтын хүрээнд						
1	<p>Нийслэлийн хөгжлийн төслүүдийн төсөвт учруулах ачааллыг нарийвчлан судлах</p>	<p>Нийслэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн төсөвт үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судална.</p>	<p>Төсөл тус бүрээр судалсан байдал</p>	<p>Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>2020-2025 он</p>
2	<p>Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн төсөвт үзүүлэх нөлөөллөөс санхүүжилтийн хувилбаруудын талаарх судалгааг хийх.</p>	<p>Төсөл тус бүр дээр хийсэн санхүүгийн судлагдсан байдал</p>	<p>Нийслэлд төр хувийн хэвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээд</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>	<p>2020-2025 он УХА.0233</p>